

АГУУЛГА

ОРШИЛ	2
БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	3
1.1. Төслийн ерөнхий мэдээлэл.....	3
1.2. Төслийн үйл ажиллагааны хураангуй.....	3
1.2.1. Уурхайн хүний нөөц, уурхайн кемп	5
1.2.2. Дэд бүтэц.....	5
БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	7
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ ... 12	
БҮЛЭГ 4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	16
БҮЛЭГ 5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	19
5.1. Байгаль хамгаалах төлөвлөгөө	19
5.1.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	19
5.1.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	22
5.1.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	22
5.1.4. Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөний хүрээнд тарих модны төлөвлөгөө	22
5.1.5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	22
5.1.6. Түүх, соёлын өвийг хамгаалах, арга хэмжээний төлөвлөгөө.....	23
5.1.7. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	23
5.1.8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	24
5.1.9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	25
5.1.10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	27
5.1.11. БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь 28	
5.2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал.....	28
ДҮГНЭЛТ	29
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	30

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт № 1 Төслийн ерөнхий мэдээлэл	3
Хүснэгт № 2 Ашиглалтын жилүүдийн хөрс хуулалт, нүүрс олборлолтын хэмжээ	4
Хүснэгт № 3 Төслийн нийт ажилчдын тоо, бүрэн хүчин чадлаар ажилласан тохиолдолд.....	5
Хүснэгт № 4 Барилга байгууламжийн мэдээлэл	5
Хүснэгт № 5 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	19
Хүснэгт № 6 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний зардал.....	22
Хүснэгт № 7 Тэрбум мод хөдөлгөөний хүрээнд тарих модны төлөвлөгөөний зардал	22
Хүснэгт № 8 Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээ	23
Хүснэгт № 9 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	23
Хүснэгт № 10 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал	24
Хүснэгт № 11 Орчны хяналт шинжилгээний төлөвлөгөө	27
Хүснэгт № 12 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	27
Хүснэгт № 13 БОМТ-ний хэрэгжилтийг төрийн байгууллага болон оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь.....	28
Хүснэгт № 14 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал.....	28

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг № 1. Тусгай зөвшөөрлийн талбайн сансрын байрзүйн зураг	3
Зураг № 2. Ил уурхайн одоогийн байдлын фото зураг	4
Зураг № 3. Тээврийн замын ерөнхий маршрут	6

ОРШИЛ

“Пауэрлэнд” ХХК-ийн Алагтогоогийн нүүрсний ордын Алагтолгойн хэсгийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчин, ногоон хөгжлийн яамны сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29 –ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлалыг баримталсан болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах, тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, БОМТ-ний хэрэгжилтийн талаар оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан.


2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт 37,466.0 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ, гарах үр дүн, хариуцах эзэн, баримталж ажиллах арга зүй, стандарт, холбогдох хууль тогтоомжийг тусгаж, зардлын задаргааг тусгав.

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хүснэгт № 1 Төслийн ерөнхий мэдээлэл

№	Ерөнхий мэдээлэл	
1	Төслийн нэр	Алагтоогоогийн нүүрсний ордын Алагтолгойн хэсгийг ил аргаар ашиглах
2	Ашигт малтмалын төрөл	Нүүрс
3	Засаг захиргааны нэгж	Дорноговь аймаг, Даланжаргалан сум, Элдэв 1-р баг
4	Төслийн хугацаа	Ордыг 10 жилийн хугацаанд ашиглана
5	Төсөл хэрэгжүүлэгч	Пауэрлэнд ХХК
6	Улсын бүртгэлийн дугаар	9011247064
7	Регистрийн дугаар	2843129
8	Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 15-р хороо, 13 хороолол, 73, 64 тоот
9	Тусгай зөвшөөрөл	Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газраас Ашигт малтмалын тухай Монгол улсын хуулийн 26 дугаар зүйлийг үндэслэн Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Арын худаг нэртэй газар орших 132.88 га талбай бүхий ашигт малтмалын MV-021717 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөл, мөн Алагтолгой нэртэй газар орших 1,278.63 га талбай бүхий ашигт малтмалын MV-021718 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2020 оны 10 дугаар сарын 07-ны өдөр “Пауэрлэнд” ХХК-д олгосон байна.



Зураг № 1. Тусгай зөвшөөрлийн талбайн сансрын байрзүйн зураг

1.2. ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ

Уурхайн одоогийн байдал

Алагтоогоогийн нүүрсний ордын Алагтолгойн хэсэгт 2010-2011 онуудад хайгуулын ажил хийж гүйцэтгэсэн ба 2012 онд ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлж В+С зэрэглэлээр нийт

1,374.10 мян.тн нүүрсний нөөц батлуулсан. Түүнээс хойш 2013 болон 2018 онуудад төслийн ТЭЗҮ-ийг ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж 2014 болон 2019 онуудад олборлолтын үйл ажиллагаа явуулж байсан байна. Энэ хугацаанд 2-В, 4-В, 14-С, 23-С блокуудад үйл ажиллагаа явуулж нийт В+С зэрэглэлээр 208.56 мян.тн нүүрс олборлож 2,436.2 мян.м³ хөрс хуулсан байна.

Уурхай нь одоогийн байдлаар дунджаар 380 м урт, 357 м өргөн, 43 м-ийн гүнтэй болсон байна.



Зураг № 2. Ил уурхайн одоогийн байдлын фото зураг

Ашигт малтмалын нөөц

Ордын нийт магадласан В' үйлдвэрлэлийн нөөц нь **1,014.10** мян.тн нүүрс, **6.45** сая.м³ хөрс болж байна. Хөрс хуулалтын дундаж коэффициент **6.36** м³/тн болж байна.

Бүтээгдэхүүн гаргалт

Алагтолгойн ил уурхайн жилийн хүчин чадлыг 100.0 мян.тн нүүрс байхаар, уурхайн хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажлыг жил бүр тогтмол тасралтгүй явуулж төлөвлөсөн хүчин чадлаар ажиллуулахаар тооцоход 10.0 жилийн хугацаанд олборлохоор байна. Уурхайн үйл ажиллагаа нь хоногт 2 ээлжтэй, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг, жилд цэвэр 312 хоног ажиллана.

Хүснэгт № 2 Ашиглалтын жилүүдийн хөрс хуулалт, нүүрс олборлолтын хэмжээ

Ашиглалтын жил	В нөөц, мян.тн	С нөөц, мян.тн	Нүүрс олборлолт В+С, мян.тн	Хөрс хуулалт, мян.м ³			Уулын цул, мян.м ³	Хөрс хуулалтын харьцаа м ³ /тн
				Шимт хөрс	Гадаад овоолго	Дотоод овоолго		
1 дэх жил	40.00	60.00	100.00	5.00	639.00	-	744.00	6.44
2 дахь жил	39.00	61.00	100.00	5.00	644.00	-	749.00	6.49
3 дахь жил	37.00	63.00	100.00	5.00	642.00	-	747.00	6.47
4 дэх жил	37.00	63.00	100.00	5.00	640.00	-	745.00	6.45
5 дахь жил	37.00	63.00	100.00	5.00	641.00	-	746.00	6.46
6-10 дахь жил	185.40	328.69	514.10	24.11	678.14	2,516.49	3,732.84	6.26
Нийт	375.40	638.69	1,014.10	49.11	3,884.14	2,516.49	7,463.84	6.36

Хөрөнгө оруулалтын хэмжээ

Алагтолгойн нүүрсний ордыг ашиглахад 2019 онд нийт 8.71 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн бөгөөд үүнээс 2019-2023 оныг дуусталх хугацааны элэгдэл хорогдлыг тооцсоноор 2023 оны эцэс дэх хөрөнгийн хэмжээ 4.39 тэрбум төгрөгийн үнэлгээтэй байна. Орд

ашиглалтын хугацаанд нийт 6.46 сая.м³ хөрс хуулалтын ажил хийж, 1,014.10 мян.тн нүүрс олборлоно. Нэг тн чулуун нүүрсийг 147,339 төгрөгөөр борлуулна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт

Орд ашиглалтын 10 жилийн хугацаанд нийт 149.42 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олж, 138.59 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны зардал гарган, 9.64 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллана. Ашиглалтын хугацаанд нийт 19.32 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал бий болно. 15%-ийн хорогдуулалтын норм (NPV) тооцсон төслийн өнөөгийн цэвэр үнэ цэнэ 2.12 тэрбум төгрөг, өгөөжийн дотоод норм (IRR) 27% байна, хөрөнгө оруулалтаа 2.6 жилд нөхнө.

1.2.1. Уурхайн хүний нөөц, уурхайн кемп

Нийтдээ Алагтолгойн уурхайд 91 хүн ажиллах ба ажилчид нь уурхай дээр 14 хоног ажиллаад 14 хоног амрахаар 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна.

Хүснэгт № 3 Төслийн нийт ажилчдын тоо, бүрэн хүчин чадлаар ажилласан тохиолдолд

№	Ашиглалтын жил	Эхний жилд
1	Төв оффис	7
2	Уулын хэсэг	44
3	Засвар, механикийн хэсэг	14
4	Аж ахуй, үйлчилгээний хэсэг	26
	Нийт	91

1.2.2. Дэд бүтэц

Ажилчдын хотхон нөөц тооцсоноор 60 хүн зэрэг байрлах хүчин чадалтай байна. Уурхайн удирдлагын байр, ажилчдын амрах байр, цайны газар, ажилчдын халуун ус, харуулын байр, сэлбэг материалын агуулах зэргийг сандвичээр барьж байгуулсан байна.

Хүснэгт № 4 Барилга байгууламжийн мэдээлэл


№	Барилгын нэр	Хэмжих нэгж	Хэмжээ
Хотхон			
1	Уурхайн удирдлагын байр	сэндвич	950.00
2	Ажилчдын сууц 1 дор 60 хүн байрлах	сэндвич	1,500.00
3	Цайны газар 1 дор 60 хүн хооллох	сэндвич	400.00
4	Халуун ус болон угаалга 10 хүний х/ч	сэндвич	220
5	Гараж	сэндвич	400
6	Харуулын байр	сэндвич	18.00
Ил уурхай			
7	ТБ-ын агуулах 60 тн х/ч	блокон	250.00
8	Хамгаалалтын хашаа	блокон	250.00
9	Засварын газар	блокон	2,500.00
10	Сэлбэгийн агуулах	блокон	300.00
11	Шатахуун түгээх газар	блокон	250.00
12	Уурын зуух	блокон	200.00

Цахилгаан хангамж: Уурхайн цахилгаан хэрэглэгчдийг төслийн талбайд байх компанийн өөрийн дизель генератороор цахилгаан эрчим хүчээр хангана.

Дулаан хангамж: Уурхайн барилга байгууламжууд нь сандвич хийцлэлтэй тул сэрүүний улиралд уурын зуухаар галлан халаана.

Усан хангамж: Уурхайн унд-ахуйн буюу хотхоны усны хэрэглээг тусгай зөвшөөрлийн талбайд өрөмдөж гаргасан 2 л/сек ундарга бүхий гүний худгаас, технологийн болон бусад усны хэрэглээг ил уурхайн шүүрлийн уснаас хангана.

Уурхайн зам: “Пауэрлэнд” ХХК нь нүүрс худалдан авагч тал болох БНХАУ-ын “Erlianhaote Juxian Import and export trade Co.,Ltd” болон нүүрс тээвэрлэгч болон “Овоо айл” ХХК нар хамтран байгуулсан гэрээгээр гадаад тээврийн нөхцөл тээврийн компаний үүргээр тодорхойлогдоно. Уурхайн ачих талбайгаас Чойрын 25-р өртөөний ачиж буулгах хэсэг хүртэл 27.8 км шороон замаар, түүнээс цааш БНХАУ-ын хил хүртэл 467 км зайд төмөр замаар тээвэрлэнэ.



Зураг № 3. Тээврийн замын ерөнхий маршрут

БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Физик газарзүйн нөхцөл:

“Алагтолгойн уурхай” нь Монгол орны цөлөрхөг хээрийн бүсийн хойт хэсэгт Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутаг Алагтолгой, Арын худаг нэртэй газарт оршино. Улаанбаатар хотоос урагш 270 км зайд, Даланжаргалан сумын төвөөс 28 км зайд байрлана. Монгол орны физик-газарзүйн мужлалаар Монголын дорнод талын их мужийн Халхын дундад ба Дарьгангын талархаг мужийн Халхын дундад ухаа гүвээт талын тойрогт багтана. Энэ бүс нутаг жижиг гүвээлэг, толгодлог гадаргуу зонхилох бөгөөд шорвог устай жижиг нуурууд, түүний хуурай ай савууд, хужирлаг цайдам, хөндий бүхий хотгоруудын хаяа, хязгаар нь алсуур налуу, сулхан хэрчигдэлтэй оршдог онцлогтой.

Алагтолгойн уурхайн газар нь толгодлог газар бөгөөд үнэмлэхүй өндөр нь 1250-1300 м, харьцангуй өндөр нь 19 м. Чулуулгийн үндсэн илэрц нь толгодын орой хэсэг мөн бага хэмжээгээр толгодын хажуу тал, хаяа, хөндий, хуурай сайруудын ёроолд тус тус тохиолддог.

Ландшафт:

Төв Азийн өндөрлөг тал, хотгор, уулт их мужийн Монголын зүүн өмнөд хэсгийн суурьт болон давхаргат өндөрлөг тал, хотгор, сэргэж хэлбэршсэн үлдмэл-цулдам уул, бэлэрхэг уулын муж, Сайншандын хотгор, суурьт болон давхаргат өндөрлөг тал, сэргэж хэлбэршсэн үлдмэл-цулдам уул, бэлэрхэг уул бүхий цөлжүү хээр, заримдаг цөлийн дэд муж, Их-Хэтийн цөлжүү хээр, хужир мараагийн бүсэд хамаарна.

Цаг уур, үүр амьсгал:

Эх газрын эрс тэс уур амьсгалтай бүсэд багтах ба хоногийн температур эрс хэлбэлздэг, хур тунадас бага, агаарын харьцангуй чийгшилт багатай, хуурайвтар байдаг. Сарын хамгийн бага дундаж температур нь нэгдүгээр сард -12° -оос -25° С, хамгийн өндөр дундаж температур нь $+20^{\circ}$ -оос $+22^{\circ}$ С байдаг. Хур тунадас бага унадаг, жилд дунджаар 160-180 мм хүрдэг. Салхины хурд зарим үед 15-18 м/сек хүрдэг.

Геологи, геоморфологи:

Геологи: Алагтолгойн уурхайн геологийн судалгаа нь 1940-өөд оноос бүс нутгийн хэмжээнд эхэлсэн бөгөөд тус судалгаагаар Алагтоогоогийн нүүрсний илрэл анх тэмдэглэгдсэн байдаг. 1954 онд А.Н.Ефимов, З.А.Кузнецов нар Алагтоогоогийн орчимд тархсан талбайг бүхэлд нь хамарсан геологийн анхны судалгааны ажлыг хийсэн бөгөөд тус судалгаанд уг талбайн геологийн тогтоц нь дунд палезой, юра, цэрд, гуравдагч, дөрөвдөгчийн хурдсаас бүрдэнэ гэж үзжээ. 1963 онд В.В.Соловьев, В.Ц.Соловьева нар Алагтоогоогийн нүүрсний орд дээр хурдавчилсан хайгуулын ажлыг хийсэн байдаг. Тус ордын нүүрсийг Г-Д маркийн нүүрсэнд хамаарагдах сайн чанарын нүүрс гэж үзсэн байна. 1998-1999 онд “Монгол Алт” ХХК нь өөрийн хөрөнгөөр Алагтоогоогийн нүүрсний ордод эрэл хайгуулын ажил хийж

Алагтоогоогийн нүүрсний орд нь Элдэв, Далан, Жаргалант, Алагтоогоо гэсэн 4 хэсгээс бүрдсэнийг тогтоож Элдэвийн хэсэгт нарийвчилсан хайгуул, Далан, Жаргалантын хэсгүүдэд эрэл үнэлгээний ажил гүйцэтгэсэн байна.

Алагтолгойн уурхайн геологийн тогтоц нь дээд юрийн конгломератын давхарга, доод цэрдийн нүүрс агуулсан эх газрын бялхмал-тунамал хурдас ба дөрөвдөгчийн эх газрын тунамал хурдсаас бүрдэнэ.

Геоморфологи:

Алагтолгойн уурхайн талбай нь Монгол орны геоморфологийн мужлалаар Монголын дорнод мужийн Баруун-Уртын дэд мужид хамрагдана. Тэгширмэл газар, уулс хоорондын хотос, уулан дундах хотгор дахь элэгдлийн гаралтай өргөгдмөл гадарга (Mz-Q), Ул чулуулаг дээрх элэгдлийн суурьт талын гүвээт, толгодот гадаргууд сайн ажиглагдана.

Гадаргын ус:

Ус зүйн хувьд дэлхийн ус хагалбарын Төв Азийн гадагш урсацгүй ай савд, Монгол орны Умард говийн гүвээт, Халтын дундад талыг сав газарт багтана. Энэ ай сав дахь ихэнх голдирол нь түр зуурын урсацтай бөгөөд жилийн ихэнх хугацаанд хуурай байдаг. Алагтолгойн уурхайн талбайд урсгал ус байхгүй. Зуны улирлын сүүлч, намраар үргэлжилсэн ширүүн борооны дараа хөндий, хуурай сайруудаар хэмхдэс чулуулаг зөөвөрлөсөн түр зуурын булингартай үерийн ус урсдаг.

Нутаг дэвсгэрийн хүрээнд худаг, шанд харьцангуй элбэг. Хүн, малын ундаанд удаан хугацаагаар хэрэглээгүй дарагдсан буюу усгүй худаг, шандууд ч нэлээд тааралдана. Гэвч эдгээрийн ихэнх нь эрдэсжилт ихтэй тул ундны болон техникийн хэрэгцээнд ашиглахад тохиромжгүй юм. Хайгуулын анги 10-15 км зайтай орших Цагаан-Усны худгаас ус авч байсан байна. Худгийн усны нөөц тогтоогдоогүй, ундарга нь 2 л/сек.

Гидрогеологи нөхцөл, газрын доорх усны нөөц, чанар, горим:

Ордын нүүрс агуулагч чулуулгийн шүүрэлтийн шинж чанар, усжилтыг тодорхойлох зорилгоор гидрогеологийн 3 цооногийг өрөмдсөн байна.

Гидрогеологийн судалгаагаар хийсэн шавхалт туршилтын ажлын үр дүнгээс харахад ордын хүрээнд усны тогтонги түвшин нь 12.3-25.1 м-ийн гүнд байрлах ба ерөнхийдөө хойноос урагш гадаргуугийн үнэмлэхүй өндөр намссанаар усны түвшин дээшилдэг. Алагтолгойн хэсгийн талбайд тархсан чулуулгийн усжилт жигд биш, хэсгийн янз бүрийн хэсгүүдэд өрөмдсөн гидрогеологийн цооногуудын ундарга 0.3-2.1 л/с байх ба хэсгийн хойд хэсэгт төв, өмнөд хэсгээсээ харьцангуй илүү усжилттай гэж үзжээ.

Дээрх судалгааны мэдээлэлүүдэд дүгнэлт хийхэд ордын хэмжээнд тархсан нүүрс агуулагч чулуулгийн усжилт нь гидрогеологийн шавхалтаар гүн рүүгээ буюу нүүрсний

давхраасуудаас доош ихссэн байна. АТ11-01Н, АТ11-02Н цооногуудад 60 м-ийн гүнээс 0.2-0.4 л/с-ээр, АТ11-03Н цооногт 40 м-ээс эхлэн 0.15-0.25 л/с-ээр нэмэгдсэн байна.

Алагтолгойн хэсгийн хүрээнд тархсан уст бүрдлүүд нь өөрийн талбайд унах агаарын хур тунадасаар тэжээгдэж, ордын хүрээнд чулуулгийн ан цаваар дамжин хуримтлагдах ба усаа гипсометрийн доор орших бусад уст давхарга, бүрдлүүдэд алдана. Талбайн гадаргуугийн байдал нь өөр бусад уст давхарга, бүрдлүүдээс тэжээгдэл авах нөхцөлөөр хязгаарлагдмал юм. Газрын доорх усны горим нь жил бүр ихээхэн хэлбэлзэлтэй, агаарын хур тунадсын хэмжээнээс шууд хамааралтай байна.

Шавхалтын ажлын төгсгөлд цооногуудаас усны шинжилгээний үр дүнгээр ордын хойд хэсэгт (цооног АТ11-01Н) газрын доорх усны эрдэсжилт нь 1.16 г/л, ерөнхий хатуулаг нь 5.64 мг-экв/л, төв, өмнөд хэсгүүдэд эрдэсжилт 2.28-2.41 г/л, хатуулаг нь 23.6-26.32 мг-экв/л байна.

Алагтолгойн хэсгийн гидрогеологийн нөхцөлөөс харахад агуулагч чулуулаг нь нүүрсний давхаргууд байрласан гүнд усжилт муутай, жигд бус тархалттай зэрэг нь ордыг ил аргаар ашиглах тааламжтай нөхцлийг бүрдүүлж байна.

Хөрсөн бүрхэвч:

Хөрсний бүтэц нь өөрийн тархалт, зузаанаараа харилцан адилгүй тархалттай. Талбайн хэмжээнд хүрэн, чулуурхаг хүрэн хөрсүүд ялгагдана. Хүрэн хөрс нь голдуу элсэнцэр, шавранцар агуулах ба чулуурхаг хүрэн хөрс нь элюви-делювийн гаралтай шавар, шавранцраас тогтоно. Хөрсний үеийн зузаан нь 0.05-0.2 м хааяа 0.3-0.4 м хүртэл хэлбэлзэнэ.

Алагтолгойн уурхайн талбай нь Монгол орны хөрс-газарзүйн мужлалаар Хангайн их мужийн Хар хүрэн, хүрэн хөрсний дэд бүс, Бор Өндөр-Уулбаяны тойрогт хамаарагдана (ШУА, Газарзүйн хүрээлэн, 2009).

Төслийн талбайд уулын хүрэн хөрс, жинхэнэ хүрэн хөрс тархсан байна. Хээрийн судалгаагаар “Алагтолгой” хэсэгт 10, “Арын худаг” хэсэгт 2, нийт 12 цэгт хөрсний зүсэлт хийсэн. Ингэхдээ хөрсний агрохимийн 12 дээж, хөрсний хүнд металл 4 дээж, эрүүл ахуй 3 задлан шинжилгээ хийлгэсэн. Шинжилгээний үр дүнгээр хөрс нь дунд зэрэг шүлтлэг урвалын орчинтой, карбонатгүй, ялзмагийн агууламж дунд, цахилгаан дамжуулах чанар бага давсжилтгүй, хөдөлгөөнт фосфор болон хөдөлгөөнт калийн хангамжаар бага байна. Хөрсний үржил шимийн ерөнхий түвшин дунд байна. Хүнд металлын агууламжаар MNS5850:2019-д заасан хөрсөнд агуулагдах хүлцэх агууламжаас бага буюу хэтрээгүй байна.

Ургамлан нөмрөг:

Алагтолгойн уурхайн талбай нь ургамал газарзүйн мужлалын хувьд Евроазийн хээрийн их муж Дагуур-Монголын дэд их муж Говийн умард-Дорнод хамаарна (Үндэсний атлас, 1990).

Төслийн талбай орчимд 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр бэлчээрийн ургамлын судалгаа гүйцэтгэхэд нийт 3 бүлгэмдэлийн 15 овгийн 31 төрлийн 40 зүйл ургамал тэмдэглэгдсэн. Энэхүү ургамлууд нь амьдралын хэлбэрийн хувьд сөөг-2 (5%), сөөгөнцөр-1 (2%), сөөгөнцөрлөг-3 (8%), олон наст- 22 (55%), нэг ба хоёр наст- 12 (30%) зүйл ургамал тус тус тэмдэглэгдсэн.

Үетэн агьт-шавагт бэлчээрийн зонхилогч зүйл нь *Artemisia frigida*-агь Шарилж, дэд зонхилогч *Artemisia caespitosa* дэгнүүлт шарилж, *Stipa krylovii*-крыловын Хялгана, *Elymus chinensis*-нангиад Түнгэ зэрэг үетэн ургамлууд бүрдүүлж байна. Үүний зэрэгцээ *Carex duriuscula*-ширэг Улалж, *Allium anisopodium*-шувуун хөл Сонгино, *Caragana stenophylla*-нарийн Харгана, *Heteroparus hispidus*-арзгар Согсоолж, *Elymus chinensis*-нангиад Түнгэ зэрэг ургамлууд зонхилон ургасан.

Хялгана- хазаар алаг өвст бүлгэмдэл (*Stipa krylovii*, *Agropyron cristatum*, *Cleistogenes songorica*, *Caragana microphylla*, *Carex duriuscula*, *Caragana stenophylla*, *Potentilla bifurca*, *Artemisia pectinata*, *Artemisia macrocephala*, *Convolvulus ammannii*, *Allium mongolicum* зэрэг ургамлууд ургана. Судалгааны талбайн 80629га талбайг бүрдүүлж байна.

Дэрст бүлгэмдэл (*Achnatherum splendens*, *Agropyron cristatum*, *Elymus chinensis*, *Artemisia frigida* зэрэг ургамлууд ургана.

Амьтны аймаг:

Алагтолгойн уурхайн байршил нь “Монгол улсын хөхтөн амьтны улаан данс”-д оруулсан мужлалын ангиллаар Дорнод говийн мужид хамрагдана. Бүс нутаг нь цөлжүү хээрийн ландшафттай тул хуурай, задгай нөхцлийг бараадан орших амьтны аймаг зонхилно. Амьтны газарзүйн мужлалаар Азийн уулархаг дэд их мужийн Монголын-Түвдийн муж, Монгол дагуурын тойрог ба говийн дэд мужийн хойд говийн тойрогт хамаарна.

Хөхтөн амьтдаас 6 багийн 23 зүйл хөхтөн амьтан тэмдэглэв. Үүнд: зараа хэлбэртэн 2, гар далавчтан 1, туулай хэлбэртэн 2, мэрэгчтэн 13, мах идэштэн 4, туруутан 1 зүйл орно. Энд хээрийн экосистемийн үндсэн гишүүд болох үнэг, хярс, чоно зэрэг махчид, цагаан зээр байхаас гадна мөн говийн амьтны аймгийн зарим төлөөлөл илэрнэ. Эдгээрээс цагаан зээр нь улирлын байдал, бэлчээрийн гарц даган нүүдэллэх байдалтай тохиолдоно.

Энэ нутагт манай орны шувуудын 33,1 хувь буюу 156 зүйл шувуу тэмдэглэгдсэн. Эдгээрээс суурин 17, нүүдлийн (өндөглөдөг) 33, нүүдлийн өндөглөдөггүй 21, дайрч өнгөрдөг 77, ирж өвөлждөг 5, тохиолдлоор үзэгддэг 3 зүйл байдаг.

Задгай ус тэг ховор учир усны шувууд бараг л тохиолдохгүй. Худаг ус, өвөлжөө, хаваржаа орчимд хадны болон хөхвөр тагтаа, хээрийн болон оронгийн бор шувуу, элээ, хотны бүгээхэй, ууль, өвөөлж, хар болон хон хэрээ, шаазгай зэрэг шувууд тохиолдно.

Эргэн тойронд 3 зүйлийн гүрвэл (монгол гүрвэл, могой гүрвэл, цоохор хонин гүрвэл), 2 зүйлийн могой (бамбай хоншоорт могой, рашааны могой) тохиолдоно. Эдгээрээс могой гүрвэл, цоохор хонин гүрвэл гэсэн хоёр зүйл нь Монголын говь, цөлд амьдардаг хамгийн өргөн тархалттай, тоо толгойн өндөр нягтшил бүхий зүйлүүд юм.

Тусгай хамгаалалттай газар нутаг, түүх, соёлын өв:

Алагтолгойн уурхайн талбайгаас газарзүйн хувьд хамгийн ойр байрлах тусгай хамгаалалттай газар нутаг нь Чойрын богд уулын байгалийн нөөц газар (БНГ) 21 км зайтай оршдог. Харин засаг захиргааны бүсийн хувьд хамгийн ойр байрдаг нь Их нартын байгалын цогцолборт газар байна. Төслийн талбай нь улсын тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалгүй. Мөн төслийн талбайд түүх, соёлын өв бүртгэгдээгүй байна.

Нийгэм, эдийн засаг:

Алагтолгойн уурхай байрлах Даланжаргалан сум нь 3007 хүн амтай, 963 өрхтэй, үүнээс 448 өрх нь Элдэв багт суурьшдаг байна. Аймгийн хэмжээнд 2024 оны 2-р сарын байдлаар нийгмийн даатгалын сангийн орлого 13602.9 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 3863.9 (39.7%) сая төгрөгөөр өссөн байна. Энэхүү өсөлтөд тэтгэврийн даатгалын сан 1986.6 (27.8%) сая төгрөгөөр, ҮОМШӨ-ний даатгалын сан 754.6 (3.2 дахин) сая төгрөгөөр, тэтгэмжийн даатгалын сан 610.9 (2.7 дахин) сая төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалын сан 384.2 (21.0%) сая төгрөгөөр, ажилгүйдлийн даатгалын сан 127.6 (2.8 дахин) сая төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Газрын гадарга болон хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл: Ил уурхайн аргаар үйл ажиллагаа явуулах учраас газрын гадаргад өөрчлөлт орно. Хөрс хуулалт, хөрсний болон нүүрсний гадаад овоолгууд, ажилтнуудын түр амьдрах байр, зэрэг бүхий л уурхайн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид нөлөөлнө.

Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн биш байдал, ШТМ алдагдах зэргээс хөрс бохирдох Ахуйн хатуу болон шингэн хог хаягдлаас үүдэн хөрсөн бүрхэвч бохирдох
Сөрөг нөлөөллийг бууруулах арга

1. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх,
2. Тээвэрлэлтийг явуулахдаа замын тогтсон маршрут гаргах, мөрдүүлэх, мөн хүнд даацын тээврийн хэрэгслийн зөөвөрт явах үеийн хурдыг тогтоох (хурдтай явах тусам тоосжилт нэмэгдэн техникт эвдрэл гарна), хяналт тавих,
3. Тогтсон маршрутын дагуу замыг услах,
4. Хатуу хаягдлыг ахуйн гарал үүслээр нь ялган ангилж хадгалах, төвлөрсөн цэгүүдэд зайлуулах, нүхэн жорлонг халж, хөрсөнд үл нэвчин соруулдаг, эсвэл бага оврын цэвэршүүлэх байгууламж бүхий жорлонтой болох
5. Машин механизмын засвар үйлчилгээ хийх үед санамсаргүй тохиолдлоор шатах тослох материал алдагдахаас урьдчилан сэргийлж засварын цех байрлах талбайг хатуу хучилттай болгох.
6. Хөрсөн бүрхэвчид тодорхой давтамжтайгаар шинжилгээ хийн хянаж байх.

Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл: Тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн шаталтаас үүсэх хорт хий агаар орчныг бохирдуулах, олборлолтын явцад суларсан нарийн ширхэгт тоос агаарт салхиар болон техникийн хөдөлгөөнөөр дэгдэх,

Олборлолтын явцад түүхий нүүрс агаартай урвалд орж өөрөө шатах процесс явагдсанаар агаар орчинд кварц, цахиурын давхар исэл агуулсан нүүрсний тоос, цочроогч хий тархаж болзошгүй зэрэг сөрөг нөлөөлөл байна. *(Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2012 оны А/44/III тоот хамтарсан тушаалын хавсралт)*

Сөрөг нөлөөллийг бууруулах арга

1. Хөрс хуулалт, тээвэрлэлтийн ажлыг аль болох салхи багатай өдөр хийж гүйцэтгэх,
2. Төслийн талбайн дотоод тээвэрлэлтийг аль болон олон салаа зам гаргахгүйгээр тээвэрлэх,
3. Зам талбайг хаврын улиралд тогтмол усалж байх шаардлагатай,
4. Орчны агаарт ялгаруулах хорт утаа хийг багасгахын тулд техникийн тогтмол засвар, үйлчилгээг хийж байх,

5. Нүүрсний шатах эрсдэлийг бууруулахын тулд аюулгүй ажиллагааны зааварчилгааг уурхайн ажилчдад тогтмол хүргүүдэг байх,
6. Нүүрсний овоолгын эзлэхүүний хэмжээг хязгаарлах, хуримтлал үүсэхээс сэргийлэх,
7. Нүүрс шатсан тохиолдолд яаралтай авах арга хэмжээний зааварчилгаатай байх,

Усан орчинд үзүүлэх нөлөөлөл: Газрын хөрсөнд ШТМ алдагдсанаар хөрсөнд нэвчин газрын доорх усыг бохирдуулах эрсдэл үүсэж болзошгүй,

Олборлолтын явцад уурхайд шүүрэн орж ирэх усыг шавхан зайлуулснаар газрын доорх усны нөөц буурах, хомстох.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга

1. Усны чанарт тогтмол хяналт шинжилгээ хийж байх. Усны чанар стандартаас давж муудсан тохиолдолд нэн тэргүүнд эх үүсвэрийг тодорхойлж, усны чанарыг муутгаж байгаа хүчин зүйлийг арилгах эсхүл бууруулах арга хэмжээг авч ажиллах шаардлагатай.
2. Машин механизмын засвар үйлчилгээ хийх үед санамсаргүй тохиолдлоор шатах тослох материал алдагдахаас урьдчилан сэргийлж засварын цех байрлах талбайг хатуу хучилттай болгох.

Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл: Хөрс хуулалт, овоолго хийх, дотоод тээвэрлэлтийн явцад ургамлан бүрхэвч устаж дарагдах, хог хаягдал, тоос тоосонцор салхиар дамжиж тархах болон хөрсөнд нэвчих байдлаар ургамал, хөрс, усыг бохирдуулах нөхцөл бүрдэнэ.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

1. Нутгийн ургамлын мониторингийн судалгааг хийж Биологийн нөхөн сэргээлтийн үе шатанд аль болох нутгийн ургамлыг нөхөн тарьж ургуулах, арчлах арга хэмжээг авах,
2. Шимт хөрсний овоолгыг тусад нь хуулж стандартын дагуу арчилж хадгалах
3. Хавар намрын хуурайшилттай үед хээрийн түймрээс урьдчилан сэргийлж зурвас татах,
4. Хог хаягдлыг нэгдсэн цэгт хуримтлуулж тогтмол зайлуулах, хог хаягдал салхинд хийсэхээс сэргийлж хогийн цэгийг хашаалах.

Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл:

Эерэг нөлөөллүүд

Амьтны аймгийн мониторинг нь энэ бүс нутаг орчмын амьтны тухай шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээллээр хангах чухал ач холбогдолтой.

Сөрөг нөлөөллүүд

Хөрс хуулалт, олборлолтын үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт, түүнийг тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн дуу чимээ, замын тоос зэргээс үүдэн ойр орчимд нутагладаг ан амьтад үргэн дайжих, амьдрах орчноо алдах зэрэг сөрөг нөлөөлөлтэй,

Олборлолт явуулж байгаа газарт болон усан санд мал, амьтан унах, хууль бус ан агнуур явагдах.

Хөрс хуулалтын үед үүссэн нүх, хөрсөнд орогнох, үүрлэх мэрэгч, мөлхөгч, шувуудын үүр ноохой сүйтгэгдэх зэрэг болно.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга

1. Уурхай болон усан сан орчын талбайг мал амьтан унаж үрэгдэхээс сэргийлж хашаалах эсхүл хамгаалалтын далан байгуулах,
2. Бүс нутгийн биологийн төрөл зүйл, тоо толгойг хамгаалах үүднээс орон нутгийн захиргаа, иргэдийн төлөөлөл, байгаль орчны албаны ажилтантай байнга хамтран ажиллах, шаардлагатай тохиолдолд тэдгээрт туслалцаа үзүүлэх, санал солилцох, тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх.
3. Хууль бус ан агнуур хийхгүй байх талаас уурхайн ажилчдад сургалт хийн, ухуулан таниулах, хяналт тавих ажлыг авч хэрэгжүүлэх.

Түүх соёлын дурсгалт зүйлст үзүүлэх нөлөөлөл: Түүх соёлын дурсгалт зүйлс нь ашиглалтанд өртөх талбайд илрээгүй байна.

Хэрэв ашигт малтмал ашиглалтын явцад хүн малын яс, шавар ваар савны хагархай, янз бүрийн хүрэл, төмөр эдлэл, түүний хэлтэрхий, хугархай гэх мэт хүний гараар хийсэн ямар нэг эд өлгийн шинж тэмдэг илэрсэн тохиолдолд орон нутгийн удирдлага, БО-ны хяналтын улсын байцаагч, цагдаагийн байгууллагад нэн даруй мэдэгдэж хамгаалалтанд авах ба дурдсан мэргэжлийн байгууллагад яаралтай хандаж малтлага судалгаа хийлгэхийг зөвлөж байна.

Төслөөс хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл: Төслийн үйл ажиллагааны явцад үүсэх тоосжилт, дуу чимээ, техник, тоног төхөөрөмжийн хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлөх магадлалтай.

Мөн нүүрс олборлох явцад нүүрсний шаталтаас хорт хий агаарт тархах ойр орчмын хүн амыг эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга

1. ХАБЭА тухай хууль, бусад холбогдолтой дүрэм журам, стандартын шаардлагуудыг мөрдөх, дотоодын хяналтын журам аюулгүй ажиллагааны заавар, зааварчилгааг нийт ажилтнуудад мөрдүүлэх, хяналт тавих шаардлагатай.
2. Нүүрсний шаталтын үед яаралтай авах арга хэмжээний заавар, зааварчилгааг боловсруулж ажилчид болон ойр орчмын айлуудад тогтмол сургалт зохион байгуулж байх шаардлагатай.

Төслөөс нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл: Улсад болон орон нутагт тодорхой хэмжээний татвар төлөх, ажлын байр шинээр хий болгох, орон нутгийн иргэдээс мах сүү, цагаан идээ зэрэг уламжлалт аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг худалдан авах зэрэг эерэг нөлөөлөл байна.

БҮЛЭГ 4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ, гол зорилт: Энэхүү тайлангийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ. Байгаль орчны хэрэгжиж бүхий нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино.

Энэхүү төлөвлөгөө нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд үндэслэгдсэн дараа дараачийн жилүүдэд хянан үзэж, шинэчлэн сайжруулж байх шаардлагатай бөгөөд байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрүүдээс гарч буй үр дүнтэй уялдуулах нь зүйтэй. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаснаар төслийн үйл ажиллагаа болон түүний хүрээлэн буй нутаг дэвсгэр дэх бүх сөрөг өөрчлөлтүүдэд үнэлгээ хийх хэрэгтэй. Мөн түүнчлэн байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн ажлын үр дүнгүүдэд үнэлгээ хийх шаардлагатай. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, нөхөн сэргээлт хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан.

БОМТ боловсруулах, хэрэгжүүлэх үндэслэл: Олон улсад түгээмэл хэрэглэгддэг тодорхойлолтоор Байгаль орчны менежмент гэдэг нь аливаа байгууллагын байгаль орчны бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх ба хэрэгжилтийн явц, үр дүнг хянах удирдлагын үйл ажиллагаа бөгөөд энэ нь Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) –ний дагуу Байгаль орчны удирдлагын тогтолцоо (БОУТ) –гоор хэрэгжих учиртай. БОМТ гэдэг нь тодорхой газар нутгийн байгаль орчныг хамгаалж холбогдох хууль журмыг сахих зорилгоор хийгдэх ажил, арга хэмжээний төлөвлөгөө юм. MNS (ISO) 2006 стандартад зааснаар БОУТ гэдэг нь байгууллагын удирдлагын тогтолцооны нэг хэсэг бөгөөд тухайн байгууллагын байгаль орчны бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх болон байгаль орчинтой холбоотой асуудлыг хариуцах үүрэгтэй.

2012 онд нэмэлт өөрчлөлт орсон Байгаль орчныг хамгаалах тухай Монгол Улсын хуулийн 31-р зүйлд зааснаар аливаа бохирдлын эх үүсвэр бүхий аж ахуйн нэгж, байгууллага нь БОМТ-ний хэрэгжилтийг хангах, өөрийн үйл ажиллагаанаас байгаль орчинд ялгаруулах хатуу, шингэн, хийн хаягдлыг хянах ажлыг зохион байгуулж ажиллуулах дотоод хяналтын нэгжтэй байх (заалт 31.7), байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг төсөвтөө тусган хэрэгжүүлэх (заалт 31.4), БОМТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50%-тай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлэх (заалт 31.10, 31.11) зэрэг үүрэгтэй (МУ хууль, БОХ тухай, 2012).

БОМТ-ний бүрдэл хэсэг, агуулга: Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулийн (МУ хууль, БОНБҮ-ний тухай, 2012) 9 дүгээр зүйлд зааснаар БОМТ

нь Байгаль хамгаалах төлөвлөгөө (БХТ), орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)-өөс бүрдэнэ (заалт 9.5). БХТ-нд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгана (заалт 9.6). ОХШХ-т төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө зардал, хугацааг тодорхойлон тусгана (заалт 9.7).

Хуульд БОМТ-ний хэрэгжилтэнд байгаль хамгаалагч, БО-ны улсын байцаагч, Засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага, БО-ны ТББ хяналт тавина гэж заасан байна. Үүн дээр тухайн газар нутагт гарч байгаа өөрчлөлтийг хамгийн сайн мэдэх нутгийн малчид, ард иргэд болон шинжлэх ухааны үндэслэлтэй үнэлгээ, дүгнэлт өгөх мэргэжлийн байгууллагын хяналт зайлшгүй байх ёстой гэж үзэн нэмж оруулсан.

Өнөөгийн байдлаар БОАЖ-ын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар БОМТ-г боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу хийж гүйцэтгэж байна.

Байгаль хамгаалах төлөвлөгөө:

- ✓ Төслийн гол болон болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ
- ✓ Уул уурхайн төслийн хаалтын үед авч хэрэгжүүлэх гол арга хэмжээ, хамрах хүрээ;
- ✓ БОМТ-г хэрэгжүүлэх хүний нөөц, БО-ны удирдлагын бүтэц зохион байгуулалт;
- ✓ БОМТ-ний хэрэгжилтийн явц, үр дүнг холбогдох төрийн байгууллага, олон нийтэд тайлагнах төлөвлөгөө;

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр:

- ✓ Нөлөөлөлд өртөж болзошгүй байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгмийн төлөв байдлын суурь мэдээлэл ба төсөл хэрэгжсэнээр түүнд гарч болзошгүй тоон ба чанарын өөрчлөлт;
- ✓ Нөлөөллийг багасгах, арилгах, нөхөн сэргээх, хоргүйжүүлэх, саармагжуулах арга хэмжээний үр дүнг хэмжих тоон ба чанарын үзүүлэлтүүд;
- ✓ Төсөл хэрэгжүүлэгчийн мөрдөн ажиллах Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, Монгол улсын хууль тогтоомж, стандарт болон хэм хэмжээний үзүүлэлтүүд;
- ✓ Хяналт-шинжилгээ хийх шаардлагатай байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, нөхөн сэргээх арга хэмжээнүүд, нөлөөллийг хэмжих хэмжигдэхүүн;
- ✓ Сорьц авах, хэмжилт хийх, түүнд дүн шинжилгээ хийх арга, байршил, хугацаа, давтамж;

БОМТ-ний бүтэц: БОМТ-ний бүрэлдэхүүнд 5 бүлэг, 7 ерөнхий хэсэгтэй.

1. Оршил
2. Төслийн товч танилцуулга
3. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн товч танилцуулга
4. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт
5. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ
6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө
7. Дүгнэлт

БҮЛЭГ 5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

5.1. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

5.1.1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт № 5 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	2026 он	Давгамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7
1. АГААРЫН ЧАНАР							
1	Уурхайн үйл ажиллагааны явцад тээврийн хэрэгслийн хөдөлгөөний улмаас тоосжилт тархах	Уурхайн тээврийн замыг тогтмол услах, мөн хуурайшил болон салхи ихтэй өдрүүдэд тухай бүрт замын услагааг хийж байх.	Уурхайн зам	төгрөг	300,000	Тогтмол	-Агаарын тухай хууль, -Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, -MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага.
2	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн яндангаас гарах хорт хий агаарт тархах	Хүнд механизмын хөдөлгүүрийн тохиргоо, засвар үйлчилгээг тогтмол хийдэг байх, хөдөлгүүрээс гарах угааны хэмжээг стандартын хүлцэх агууламжийн хэмжээнд байлгах арга хэмжээ авах	Тээврийн хэрэгсэл, хүнд машин менинизм, тоног төхөөрөмжүүд	төгрөг	4,000,000	Тогтмол	-MNS 0017-2-3-16:1998 (хүн ам суурьшсан хэсгүүдэд) Бензин хөдөлгүүрт MNS 5013:2003 Дизель хөдөлгүүрт MNS 5014:2003 -MNS 4890:2000. ХААЭА. Ажлын байрны орчин, Эрүүл ахын шаардлага.
3	Салхи, шуурга ихтэй үед овоолгын хөрс хийсч агаар орчныг бохирдуулах, үзэгдэх орчныг халхлах	Шимт хөрсний түр овоолгыг хөрсний үржил шим алдагдахаас сэргийлж ургамалжуулах, тогтмол услаж ногоон байгууламж бий болгох	Хөрсний түр овоолго	төгрөг	300,000	Тогтмол	-MNS 3383:1982. Агаар мандал. Бохирдуулагчийн эх үүсвэрийг тодорхойлох -MNS 12.1.009:1985 ХАБ. Дуу чимээ. Барилга байгууламжийн үеийн дуу чимээний зөвшөөрөгдөх түвшин.

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт хэрэгжиж буй
 “Алагтогоогийн нүүрсний ордын Алагтолгойн хэсгийг ил аргаар ашиглах” 2026
 төслийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	2026 он	Давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7
							-MNS 12.1.06:1988 ХАБ-ын стандартын систем. Дуу чимээний хамгийн өндөр түвшин. Аюулгүй байдлын шаардлага. -MNS 12.4.005:1985 Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа. Дуу чимээнээс хамгаалах багажийг ашиглах арга
2. ГАДАРГЫН БА ГАЗРЫН ДООРХИ УСНЫ НӨӨЦ							
1	Усыг хэтрүүлэн ашигласны улмаас усны нөөц хомстох	Ус ашиглалтын бүртгэл хөтөлж, усны тайланг тогтмол гаргаж зохих газар нь хүргүүлж тайлагнах, ус ашиглалтай холбоотой гэрээ, зөвшөөрлийг авч, хүчинтэй хугацааг хянаж ажиллах	Уурхайн удирдлага болон хариуцсан ажилчид	төгрөг	Дүгнэлтэд заасны дагуу	Тухай бүрт, жил бүр	-Усны тухай хууль, -Ус ашигласны төлбөр (2013 оны 327-р тогтоол) -Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль -“Усан орчны чанарын үзүүлэлт” MNS 4586:1998. -“Газар доорх усыг бохирдлоос хамгаалах” MNS 3342:1982 -Ус ашигласны төлбөр тооцох аргачлал (Засгийн газрын 2013 оны 9-р сарын 21-ний өдрийн 327-р тогтоол)
3	Шатах, тослох материал асгарч гадаргын усыг бохирдуулах, газрын хөрсөнд нэвчих газрын доорх усыг бохирдуулах	Шатах, тослох материалыг зориулалтын саванд хадгалах, шаардлагагүй тохиолдолд задлаж битүүмжлэлтийг алдагдуулахгүй байх, асгарч алдагдахаас сэргийлэх, зориулалтын агуулахад хадгалах, тогтмол хяналт тавьж ажиллах. Засварын газар болон шатахуун түгээх газрын талбайг зохих стандартын дагуу хатуу хучилттай болгох.	Шатах, тослох материалын агуулах, ШТС, засварын газар	төгрөг	2,500,000	Барилга байгууламж барих явцад, цаашлаад үйл ажиллагааны явцад тогтмол	
3. ХӨРСӨН БҮРХЭВЧ, УРГАМЛАН НӨМРӨГ							
1	Олон салаа зам үүссэний улмаас хөрсний үржил шим байхгүй болох, хөрс талхлагдах, улмаар тоосжилт үүсэх	Тээврийн хэрэгслийн замыг зураг төслийн дагуу тавих, маршрутыг зохион зохих тэмдэг тэмдэглэгээнүүдийг байршуулах, хэрэгжилтэд тотмол хяналт	Уурхайн зам	төгрөг	500,000	Барилга байгууламж барих явцад, цаашлаад үйл ажиллагааны явцад тогтмол	-Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль,

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт хэрэгжиж буй
 “Алагтогоогийн нүүрсний ордын Алагтолгойн хэсгийг ил аргаар ашиглах” 2026
 төслийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	2026 он	Давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7
		тавиж ажиллах. Цаашид шаардлагатай тохиолдолд сэргээн засварлах.					-MNS 3297:1991 Хөрс. Хот суурин газрын эрүүл ахуйн үзүүлэлтүүд -MNS 5850:2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ -MNS 4601:2011 Автотээврийн хөдлөх бүрэлдэхүүн. Техникийн үйлчилгээ, засварын тогтолцоо -Хог хаягдлын тухай хууль, -MNS 5344:2011 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага.
4. АМЬТНЫ АЙМАГ							
1	Хууль бус ан, агнуурын улмаас бодьгалын зүйлийн тоо багасах	Уурхайн ажилчдад ан амьтад болон хууль бус ангийн талаар сургалт зохион байгуулах, Амьтан хамгаалах, судлах, хяналт тавих талаар орон нутгийн байгаль орчны алба, иргэдтэй хамран ажиллах хамтын ажиллагаа бий болгох	Төслийн талбай орчим	төгрөг	500,000	Тухай бүрт	"Амьтны аймгийн тухай" хууль: 6.1.7 дахь заалт: үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны явцад амьтан хөнөөгдөхөөс сэргийлэх
2	Мал амьтны гоц халдварт өвчин тархах	Зэрлэг амьтан агнахгүй байх, мэрэгчид ихсэхээс сэргийлж ажилчдын тосгонд ариутгал халдваргүйжлийн арга хэмжээг тасралтгүй хэрэгжүүлэх	Төслийн талбай орчим	төгрөг	200,000	Тогтмол	
Нийт				төгрөг	8,300,000		

5.1.2. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн батлагдсан ТЭЗҮ-д тусгасны дагуу уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн ажлыг төслийн сүүлийн жил болох 11 дэх жилээс хийж хэрэгжүүлнэ. Иймд 2026 онд нөхөн сэргээлтийн ажил хийх боломжгүй гэж үзэн энэхүү тайланд нөхөн сэргээлтийн зардал тусгаагүй болно.

5.1.3. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд Их нартын Байгалийн нөөц газрын Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан ажлыг хамтран хийх эсвэл Дорноговь аймгийн Байгаль орчны газар, Даланжаргалан сумын Байгаль орчны газартай зөвшилцөн төсөвт өртгийн хүрээнд хамтран ажиллахаар төлөвлөлөө.

Хүснэгт № 6 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний зардал

Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нийт зардал, төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7
Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	Их нартын Байгалийн нөөц газрын менежментийн төлөвлөгөө эсвэл Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Байгаль орчны газрын саналын дагуу ажиллах	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	1	22,000,000	2026 он	Албан санал
Нийт				22,000,000		

5.1.4. ТЭРБУМ МОД ТАРИХ ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД ТАРИХ МОДНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Пауэрлэнд” ХХК нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10-р сарын 04-ны өдрийн А/58 зарлигийн 2-т заасан тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөний хүрээнд Дорноговь аймгийн Даланжаргалан сумын засаг даргын 2026.03.26-ний өдрийн 01/192 тоот саналаар “тус сумын иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд зориулан 3,000 ш хайлаас мод дэмжлэг үзүүлэх” гэсний дагуу хамтран ажиллан ажлыг хийж гүйцэтгэнэ.

Хүснэгт № 7 Тэрбум мод хөдөлгөөний хүрээнд тарих модны төлөвлөгөөний зардал

№	Хийгдэх ажил	Тарих модны тоо /ш/	Хэмжих нэгж	Зардал 2026 он
1	2	3	4	5
1	Хайлаас модны суулгацаар дэмжлэг үзүүлэх	3,000	төгрөг	3,000,000

5.1.5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн төлөвлөлтөөр уурхайн үйл ажиллагааны үед нөлөөлөлд өртөх 1 айл байгаа бөгөөд төслийн ТЭЗҮ-ийн төлөвлөлтөөр 6-7 дахь жилээс уурхайн тэлэлтээс хамааран нүүлгэн шилжүүлэх шаардлага үүснэ. Иймд энэ удаагийн БОННУ-нд нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө тусгаагүй болно.

Тиймээс 2026 онд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөөгүй болно.

5.1.6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбай нь түүх, соёлын дурсгалт газартай давхцалгүй. Дорноговь аймгийн Даланжаргалан сумын засаг даргын 2026.03.26-ний 01/192 тоот саналын дагуу “Монголын ёс заншил, соёл урлаг, соёлын өвийг хамгаалах чиглэлээр соёлын биет бус өвийг түгээн дэлгэрүүлэх сурталчлан таниулах хойч үед өвлүүлэх зорилгоор сургалт суртчилгааны ажлыг хийх хүсэлтэй байгаа тул холбогдох зардлыг шийдэж хамтран ажиллана уу” гэсний дагуу холбогдох зардлыг шийдэж хамтран ажиллахаар төлөвлөлөө.

Хүснэгт № 8 Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээ

№	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Зардал 2026 он	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5
1	Монголын ёс заншил, соёл урлаг, соёлын өвийг хамгаалах чиглэлээр соёлын биет бус өвийг түгээн дэлгэрүүлэх сурталчлан таниулах хойч үед өвлүүлэх зорилгоор сургалт суртчилгааны ажлыг хийх	Тус сумын иргэд, олон нийт	Зардлын дүнгээр хамтран ажиллах	Даланжаргалан сумын засаг даргын 01/192 тоот албан санал

Цаашид “Пауэрлэнд” ХХК нь уурхайн ашиглалтын явцад хэрэв хүн малын яс, шавар ваар савны хагархай, янз бүрийн хүрэл, төмөр эдлэл, түүний хэлтэрхий, хугархай гэх мэт хүний гараар хийсэн ямар нэг эд өлгийн шинж тэмдэг илэрсэн тохиолдолд орон нутгийн удирдлага, БО-ны хяналтын улсын байцаагч, цагдаагийн байгууллагад нэн даруй мэдэгдэж хамгаалалтанд авах ба дурдсан мэргэжлийн байгууллагад яаралтай хандаж малтлага судалгаа хийлгэх шаардлагатай. Мөн биет болон биет бус соёлын өвийг хамгаалах ЮНЕСКО-ийн конвенцийг мөрдлөг болгон уурхай орчмын дурсгалт газрууд, өнгөрсөн үеийн хүн төрөлхтний түүхийн дурсгалууд, биет бус соёлын өв болох бүжиг, хөгжим, уламжлалт ахуй зэрэг соёлын олон янз байдлыг бий болгох гол хүчин зүйлсийг хадгалан үлдэх, хамгаалах чиглэлээр ажиллах ба энэ талаар авах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж жил бүрийн БОМТ-д тусган хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэгтэй.

5.1.7. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт № 9 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	2026 он	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7
1	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжөөс шалтгаалж гэнэтийн осол гарах	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, үзлэг хийж засварлах, хянах, шаардлагатай тохиолдолд шинэчлэх.	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж	-	Тогтмол	-Гамшгаас хамгаалах тухай хууль, 2003 (сүүлийн нэмэлт өөрчлөлт 2012 оны 5 сарын 17) -MNS6010-2009
2		Галын дохиоллын систем суурилуулах,	Уурхайн барилга	500,000	Уурхайн ашиглалт	Гамшгийн холбогдолтой

3	Гэнэтийн гал түймрийн аюулын үед үүсэх эрсдэл	гал унтраах хэрэгсэл, галын аюулын тухай самбар, тэмдэг, тэмдэглэгээг зохих газруудад байрлуулах Мананцар үүсгэгч, нүүрсний чийг хэмжигч авах	байгууламж болон ил уурхай орчимд		эхлэхийн өмнө, цаашид тухай бүрт	нэр томьёо, тодорхойлолт, ерөнхий анги -MNS ILO OSH 1:2003, “ХААЭА-н удирдлагын тогтолцооны талаарх удирдамж” -Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль -MNS ISO 13688:2000, “ХААЭА. Хамгаалалтын хувцас. Ерөнхий шаардлага”
		Галын болон болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар мэргэжлийн байгууллагатай хамтран уурхайн ажилчдын дунд сургалт зохион байгуулах	Ажилчид	500,000	Жил бүр	
4	Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллаагүйн улмаас эрүүл мэндэд учруулж болзошгүй гэнэтийн осол эрсдэл	Болзошгүй осол, хүний амь насанд аюул учруулж болох нөхцөлүүдээс урьдчилан сэргийлэх, ХАБЭА-ны болон АУТөлөвлөгөөтэй байх.	ХАБЭА, БО-ны мэргэжилтнүүд	-	Жил бүр	
5	Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллаагүйн улмаас эрүүл мэндэд учруулж болзошгүй гэнэтийн осол эрсдэл	Уурхайн ажил эхлэхийн өмнө тогтмол ажилчдын дунд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар сургалт зохион байгуулдаг байх.	Ажилчид	-	Тогтмол	
6	Байгалийн давагдашгүй хүчин зүйл	Байгалийн аюул гамшгийн үед авах арга хэмжээний талаар мэдээлэл ажилчдад өгөх, урьдчилан сэргийлэх зөвлөмж гаргах	Ажилчид	100,000	Тогтмол	
Нийт				1,100,000		

5.1.8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

“Пауэрлэнд” ХХК нь уурхайн үйл ажиллагаанаас бий болж буй хог хаягдлын хэмжээг багасгах, аль болох бага хог хаягдал үүсгэх, түүнийг дахин ашиглах болон дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын хэмжээг бууруулах, үлдсэн хог хаягдлыг хүрээлэн буй орчинд аюулгүй байдлаар устгах зарчмыг баримтлан ажиллах шаардлагатай.

Хүснэгт № 10 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	2026 он	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт ба аргачлал
1	2	3	4	5	6
1	Хог хаягдал ангиалан ялгаж хаях зориулалттай	Уурхайн тосгон	300,000	Уурхайн ашиглалт	-Хог хаягдлын тухай хууль;

	хогийн савнуудыг тосгон, захиргаа, цайны газар зэрэг шаардлагатай газруудад байршуулах			эхлэхийн өмнө, цаашид шаардлагатай тохиолдолд	-БОАЖ-ын сайдын А/433 тушаал “Ариун цэврийн тухай” хууль; -БОАЖ-ын сайдын 2017 оны А/349 тушаал - Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэл; -БОАЖ-ын сайдын 2017 оны А/368 тушаал - Энгийн хог хаягдлын норматив хэмжээг тогтоох аргачлал; -БОАЖ-ын сайдын 2018 оны А/18 тушаал - Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах; -БОАЖ-ын сайдын 2018 оны А/443 тушаал - Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага; -БОАЖ-ын сайдын 2018 оны А/445 тушаал - Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах, үйл ажиллагаа явуулах, хаах аргачилсан заавар; -БОАЖ-ын сайдын 2018 оны А/21 тушаал, MNS 5344:2011. Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага;
2	Хог хаягдлын цэгийг битүүмжлэл сайтай байхаар байгуулж, хашаалах, цаашид шаардлагатай тохиолдолд сэргээн засварлах	Хогийн цэг	300,000		
3	Орон нутгийн тохижилт үйлчилгээний байгууллагатай гэрээлэн хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулж байх	Уурхайн удирдлага болон хариуцсан ажилтан	1,200,000	Тогтмол	
4	Үйлдвэрийн болон барилгын хог хаягдлыг тусад нь хатуу хучилттай талбайд эсхүл газрын хөрсөнд нэвчихээргүй хамгаалсан дэвсгэр дээр цуглуулах, дахин ашиглаж, дахин боловсруулах боломжтой хаягдлуудыг аль болох хоёрдогч түүхий эд авах цэгт тушаах.	Дугуй, модны хаягдал, автомашины сэлбэг, төмрийн хаягдал, хавтан, блок гэх мэт	100,000	Тогтмол	
Нийт			1,900,000		

5.1.9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардлын хэмжээг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 12 сарын 27-ны өдрийн А/642 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Орчны чанарын хяналт шинжилгээний ажил, үйлчилгээний хөлс, үнэ тариф”-ыг үндэслэн тооцов.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутаг дэвсгэрт “Алагтоогоон нүүрсний ордын Алагтолгойн хэсэг”-ийг олборлохоор “Пауэрлэнд” ХХК-аас явуулж байгаа үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа болон үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөлөх байдлын

үнэлгээний нэг чухал баримт бичиг юм. ОХШХ нь БОХТ-тэйгөө нягт уялдсан байх бөгөөд байгаль орчныг хамгаалахаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг илэрхийлж, уг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр ашигтай байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд юуг анхаарах шаардлагатайг зааж өгнө. Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Ашигт малтмалын тухай Монгол Улсын хуулиудын дагуу батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулах шаардлагатай. Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээний үр дүнгүүдийг жил бүрийн 11 сард холбогдох сум, аймаг, төрийн захиргааны төв байгууллагуудад хүргүүлэн хянуулж, дараа оныхоо төлөвлөгөөг батлуулж ажиллах ёстой.

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт хэрэгжиж буй
 “Алагтогоогийн нүүрсний ордын Алагтолгойн хэсгийг ил аргаар ашиглах” 2026
 төслийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт № 11 Орчны хяналт шинжилгээний төлөвлөгөө

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Цэгийн тоо	Давтамж, жил	2026 он	Баримтлах стандарт, арга, аргачлал
1	2	3	4	5	6	7
1. Агаарын чанар						
1	(PM10, PM2.5, SO ₂ , NO ₂ , CO)	Ил уурхай, тээврийн зам, нүүрсний овоолго орчимд зонхилох салхины чиглэлд	4	2	400,000	- Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль -MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
2	Дуу шуугиан	Ил уурхай, тээврийн зам, уурхайн хотхоны орчимд	3	1	15,000	- MNS 0017-2-3-16:1988. Агаар мандал. Хот суурингийн агаарын бохирдлын шинжилгээ
2. Хөрсний чанар						
1	Агрохими	Ил уурхай, тээврийн зам, уурхайн хотхон тус бүр 1 цэгээс	3	2	360,000	-MNS 3473:1983 Газар. Газрын эдэлбэр. Газар ашиглалт.
2	Хүнд металл	Ил уурхай, ШТМ-ын агуулах, нүүрсний овоолго тус бүр 1 цэгээс	3	1	126,000	-MNS 3985: 87. Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл
3	Эрүүл ахуй	Ариун цэврийн байгууламж, хогийн цэг, уурхайн хотхон тус бүр 1 цэгээс	3	1	90,000	-MNS 3310:91. Хөрсний агрохимийн үзүүлэлтийг тодорхойлох
3. Усны чанар						
1	Усны ерөнхий үзүүлэлтүүд, Микробиологийн шижилгээ	Гүний худаг	1	2	130,000	- MNS 0900:2018. Ундны ус, ундны усны хяналт шинжилгээ - MNS 3934:1986 Ундны болон үйлдвэрийн ус-химийн шинжилгээ хийх-дээж авах, хадгалах, зөөвөрлөх
2	Хаягдал усны шинжилгээ	Шүүрлийн ус	1	1	45,000	- MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага.
Нийт					1,166,000	

5.1.10. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт № 12 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	2026 он	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	БО мэргэжилтэн	Үйл ажиллагааны зардал	Жил бүр	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт хэрэгжиж буй
 “Алагтоогоогийн нүүрсний ордын Алагтолгойн хэсгийг ил аргаар ашиглах” 2026
 төслийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2	БОХ талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах	Уурхайн дарга	Үйл ажиллагааны зардал	Жил бүр	
3	Даланжаргалан сумын ногоон байгууламжийн усалгаа арчилгааг хийх нэг иргэнийг туслах ажилтнаар ажиллуулж цалинжуулах	Уурхайн дарга	Дотоод төлөвлөлтөөр	IV-X сард	Даланжаргалан сумын засаг даргын 01/192 тоот албан санал

5.1.11. БОМТ-НИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ

Хүснэгт № 13 БОМТ-ний хэрэгжилтийг төрийн байгууллага болон оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

№	БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
1	2	3	4	5	6	7
1	Дорноговь аймаг, Даланжаргалан сум, Элдэв багийн ИНХ	Уулзалт, санал асуулга, тайлан хэлбэрээр	БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах	11-р сард	Нутгийн иргэдийн саналыг авах	Дорноговь аймаг Даланжаргалан сум
2	БОУАӨЯ	Тайлангийн эх хувь, албан бичиг	Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх	12-р сар	Тайлагнах	БОУАӨЯ
3	Байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, Бүх шатны засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага	Танилцуулж тайлагнах	Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн талаар	Хагас жил тутам буюу 6, 11 сард	Цаашид анхаарах асуудал	Засаг даргын тамгын газар

5.2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДАЛ

Хүснэгт № 14 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	х.нэгж	2026 он
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	төгрөг	8,300,000
2	Тэрбум мод хөдөлгөөний хүрээнд тарих модны төлөвлөгөө	төгрөг	3,000,000
3	Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	төгрөг	22,000,000
4	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	төгрөг	1,100,000
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	төгрөг	1,900,000
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	төгрөг	1,166,000
Нийт		төгрөг	37,466,000

Алагтолгойн уурхайн төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардалд 2026 онд 37,466.0 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөө.

ДҮГНЭЛТ

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт хэрэгжиж буй “Алагтогоогийн нүүрсний ордын Алагтолгойн хэсгийг ил аргаар ашиглах” төсөлд Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай хууль”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль” зэрэг хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжуудад тулгуурлан байгаль орчны тухайн жилийн менежментийн төлөвлөгөөг хийлээ.

“Пауэрлэнд” ХХК-ний байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахад дараах дүгнэлтэнд хүрлээ.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг мөрдлөг болгон цаг хугацаанд нь хэрэгжүүлэх шаардлагатай.

Барилгын чулууны ордын үйл ажиллагааны явцад хөрс хамгийн ихээр элэгдэл эвдрэлд орох учир нөхөн сэргээлт хийх зайлшгүй шаардлагатай.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардалд 2026 онд 37,466.0 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөжээ. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.10 -т зааснаар төсөл хэрэгжүүлэгч нь үйл ажиллагааныхаа бүхий л үе шатанд байгаль орчинд учирч болох сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, байгалийн баялгийг зохистой ашиглах, Монгол улсын холбогдох хууль тогтоомжууд болон олон улсад нийтээр хүлээн зөвшөөрсөн байгаль орчны стандартуудыг дагаж мөрдөж байгаа эсэхэд хяналт тавих, байгаль орчинд халгүй үйл ажиллагаа явуулах үр ашгийг тогтмол дээшлүүлэх, шинэ дэвшилтэт технологийг хөгжүүлэн нэвтрүүлэхэд зарцуулах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхийн баталгаа болгож, нөхөн сэргээлтийн тусгай дансанд ашиглалтын үйл ажиллагаа дуусах хүртэл жил бүр тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 %-ийг БОУАӨЯ-ны төсөвт байршуулах шаардлагатай.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний арга хэмжээнүүдийг цаг тухайд бүрт мөрдлөг болгож, хэрэгжүүлсэн нөхцөлд энэхүү төслийг цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх бүрэн боломжтойгоос гадна шинээр ажлын байр нэмэгдэх, орон нутагт их хэмжээний хөрөнгө оруулалт хийгдэх төлөвлөгөөтэй байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших Алагтогоогийн нүүрсний ордын Алагтолгойн хэсгийг ил аргаар ашиглах ТЭЗҮ-ийн тодотгол-2
2. Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших Алагтогоогийн нүүрсний ордын Алагтолгойн хэсгийг ил аргаар ашиглах төслийн “Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан” УБ, 2024 он
3. Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших Алагтогоогийн нүүрсний ордын Алагтолгойн хэсгийг ил аргаар ашиглах төслийн “Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан” УБ, 2024 он
4. Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995 он
5. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 2012 он
6. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний аргачилсан заавар УБ 2010.
7. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын стандартуудын эмхтгэл УБ 2010.
8. “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” Сайдын А/618 тоот тушаал, 2019 он
9. “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам” Засгийн газрын 58-р тогтоол, 2023 он
10. Байгаль орчны сайдын тушаал: 2014 оны 04-р сарын 10-ны өдрийн А-117 тоот тушаал, Байгаль орчны үнэлгээний аргачилсан заавар.
11. <http://www.legalinfo.mn>